



Б И М А У
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 12 сарын 25

№ 369

Улаанбаатар хот

Барилгын бэлдэг аж бүрдүүлэлтийн "БИБ" компани байгуулах тухай

Мэргэжлийн ажлын онцлог болон нийт хөрөнгийн хэмжээ, аж ахуйн нэгжийн хуулийг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Барилгын II компанийн Барилга үйлдвэрлэлийн комбинатыг Барилгын бэлдэг аж бүрдүүлэлтийн "БИБ" компани /УУГ/ болгон еөрчилж, аж ахуйн биеэ даасан тооцоон дээр ажиллуулсугай.

2. "БИБ" компанийг Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны шууд харьяанд ажиллуулан дүрмийг хэвсралт ёсоор баталсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЗЭХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Л.ЭНЭБИШ

Ц.БОЛДСАЙХАН

Улаанбаатар хотын Ардын Хурлын
Гүйцэтгэх захиргааны 1991 оны
369 дугаар тогтоолоор батлав.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТ-
ГЭХ ЗАХИРГААНЫ ХАРЬГА БЭЛДЭЦ ИЖ БҮР-
ДҮҮЛЭЛТИЙН "БИБ" КОМПАНИ /УҮГ/-ИЙН
ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Барилгын бэлдэц иж бүрдүүлэлтийн "БИБ" компани нь хөрөнгө оруулалт, технологийн шинэчлэлийн банкинд харилцах данс бүхий аж ахуйн бүрэн тооцооны үндсэн дээр ажиллах, БНМАУ-н мөрдөгдөж байгаа хууль тогтоомж болон энэ дүрэмд зохицуулан үйл ажиллагаагаа явуулах Улаанбаатар хотын Ажилчны дүүрэг дэх төрийн өмчид тулгуурласан цаашид "БИБ" компани гэж нэрлэгдэх улсын үйлдвэрийн газар мөн.

2. Компаний үндсэн зорилт нь иргэн ба үйлдвэр, соёл үйлчилгээний барилга байгууламж барьж байгаа байгууллага, компани, хувийн аж ахуй, хоршоодыг барилгын хийц материалаар хангах, хамтын ажиллагаа, хамтарсан үйлдвэрийн үндсэн дээр үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа явуулах, техник технологийг шинэчлэн хөдөлмөрийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлж, ажилчдынхаа амьдралын нөхцлийг баталгаажуулахад оршино.

3. Компани нь улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн биеэ даасан хуулийн этгээдийн эрх эдлэх бөгөөд өөрийн нэр бүхий тэмдэг, хэвлэмэл хуудсыг албан хэрэгтээ хэрэглэнэ.

Хоёр. "БИБ" компанийн бүтэц, эрхлэх ажил

1. "БИБ" компани нь захиргаа аж ахуй, зуурмагийн завод, төмөр хийц, сантехник салхивчийн цех, мод боловсруулах цех болон ацетилен кислородын станц, бусад хамтын ажиллагаатай нэгжүүдээс бүрцэнэ.

2. Компани нь төрийн өмчид тулгуурласан нэг гишүүнтэй /УҮГ/ байж өөрийн үйл ажиллагааг барилга угсралтын байгууллагуудыг төмөр хийц, сантехник салхивчийн бэлдэц, модон эцлэл, зүсмэл материал болон зуурмаг, ацетилен, хүчил төрөгчөөр захиалгын дагуу хангах, бусадтай хамтарч өргөн хэрэглээний зарим бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажлыг эрхлэнэ.

2.

Гурав. "БИБ" компанийн /УУГ/ удирдлага

1. Компанийн үйл ажиллагааг ерөнхий захирал удирдаж, Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд ажлаа хариуцан тайлагнана.

2. Компанийн ерөнхий захирлыг хотын гүйцэтгэх захиргаатай хийсэн гэрээний үндсэн дээр Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны даргын захирамжаар, ерөнхий инженер, ерөнхий ня-бо, орлогч дарга, цех хэсгийн дарга нарыг компанийн ерөнхий захирлын тушаалаар тус тус томилно.

3. Компани нь ерөнхий захирлаар удирдуулсан захиргааны гишүүдтэй байж цаг үеийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд эцгээр гишүүд нь бусад аж ахуйн нэгжийн гишүүн, удирдлагын бүрэлдэхүүнд байхыг хориглоно. Харин хувьцаа эзэмшигч байж болно.

4. Ерөнхий захирал нь компанийг төлөөлж дор дурдсан эрх эдэлнэ.

а/ "БИБ" компанийн нэрийн өмнөөс бусад байгууллага, иргэнтэй шууд харилцаж хөдөлмөр, иргэний болон бусад гэрээ байгуулах, хэлцэл хийх;

б/ Компанийн эд хөрөнгийг БНМАУ-ын хууль тогтоомжинд заасны дагуу захиран зарцуулах;

в/ Компанийн үйлдвэрлэл, технологийн нууцал хамаарах мэдээллийг тогтоох;

г/ Компанийн ерөнхий захирал нь БНМАУ-ын хууль тогтоомжинд нийцүүлэн тушаал заавар гаргана. Тушаал зааврыг "БИБ" компанийн үйл ажиллагааны хүрээнд мөрдөнө.

д/ Үйлдвэрлэлийн зарим цех нэгжийг хувьчлах, хорших, хамтын үйлдвэр байгуулах журмаар нийгэмд үр ашигтай байлгах тооцоо дүгнэлтүүдийг гаргаж хэрэгжүүлэх, гэрээ түрээсээр ажиллуулах, бусад төрлийн үйлдвэрлэл үйлчилгээ нээх, гадаад дотоодод салбар гаргах;

е/ Компанийн эрх ашгийг хохироосон буюу өөр замаар хөндсөн тохиолдолд шүүх, хуулийн байгууллагаар эрхээ хамгаалуулах, нэхэмжлэл гаргах.

3.

Дөрөв.Компанийн эд хөрөнгө

1.Компанийн эд хөрөнгийн эх үүсвэр нь үндсэн сан, эргэлтийн хөрөнгө, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний болон бусад үйл ажиллагаанаас олсон орлого, бүх төрлийн зээл, БНМАУ-ын хууль тогтоомжид харшлаагүй бусад эх үүсвэр байна.

2.Компанийн үндсэн ба эргэлтийн хөрөнгийн хэмжээгээр эхлэлийн тайлан тэнцэлд дүрмийн санг 27,1 сая төгрөгөөр тооцно.

3.Эргэлтийн хөрөнгийг уширцах дээд байгууллагатай тохиролцон өөрөө тогтооно.

Тав.Компанийн орлого

1.Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтаас олох орлого.

2.Үйлдвэр хөгжүүлэх, шинэчлэхэд зориулж улсаас авсан төрөл бүрийн зээл

3.Хуучин тоног төхөөрөмж, багаж хэрэгслэл, илүүцэлтэй сэлбэг материал борлуулсан орлого

4.Бусад орлого

Зургаа.Компанийг татан буулгах, өөрчлөн байгуулах

1.Компани нь БНМАУ-ын аж ахуйн нэгжийн тухай хуулийн 5-р зүйлд заасан үндэслэл, Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны шийдвэрээр үйл ажиллагааг зогсооно.

2.Компанийн эцсийн тооцоог хууль тогтоомжинд заасан журмаар тусгай комисс томилон тооллого үнэлгээ хийж нийтэд зарлан мэдээлж татан буулгана.